

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр, Лхагва гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-9
<hr/>	
<i>1. Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/</i>	3-4
<i>2. “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	4-9

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Хууль зүйн байнгын хорооны 12 дугаар сарын 20-ны өдөр  
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 18 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Л.Мөнхбаатар;

Чөлөөтэй: Г.Амартүвшин, Ж.Сүхбаатар, Ц.Сэргэлэн;

Эмнэлгийн чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Ц.Мөнхцэцэг, Ш.Раднаасэд;

Тасалсан: Н.Алтанхуяг.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх П.Хулан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Тогтоолын төслийн танилцуулгыг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар хариулж, тайлбар хийв.

**Д.Цогтбаатар:** “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр. “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх П.Хулан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Тогтоолын төслийн танилцуулгыг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Ш.Адъяа нарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

**Д.Цогтбаатар:** “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 11 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 27 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 11 цаг 45 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим, 11 цаг 18 минут

### **ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Д.Цогтбаатар:** Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны гишүүд ээ, энэ өдрийн мэндийг эрье. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Ирц бүрдсэн байгаа. Ирцийн материал Цогтбаатар гишүүн, Ширнэнбандийн Адьяаа гишүүн ирсэн байна. Сандагийн Бямбацогт гишүүн ирсэн байгаа. Дашидондогийн Ганбат гишүүн ирсэн байгаа. Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн ирсэн байгаа. Цэндийн Мөнх-Оргил гишүүн ирсэн байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн байна. Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн байна. Ням-Осорын Учрал гишүүн ирсэн байгаа. Баттөмөрийн Энхбаяр гишүүн ирсэн байгаа. Тэгээд Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн ирснээр ингээд ирц 57,9 хувьтайгаар бүрдсэн байна.

Өнөөдрийн хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх 2 асуудал байгаа.

Эхний асуудал “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.

2 дахь нь “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу. Тэгвэл ингээд саналтай гишүүн алга байна. Хэлэлцэх асуудлыг баталлаа. Хэлэлцэх асуудалдаа орёе:

**“Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.**

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Пүрэвдорж гишүүн. Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

**Б.Пүрэвдорж:** Би 3 жилийн өмнө 1 хуулийн төсөл өргөн барьсан. Өөрөөр хэлбэл Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль байгаа. Тэгэхээр 2017 оны 1 сарын 1-нд Эрүүгийн хуульд өөрчлөлт ороод, тэгээд тэр дээр яасан бэ гэхээр “гүтгэх” гэдэг заалт орж ирсэн юм. Тэгээд “гүтгэх” гэдэг заалт сэтгүүлч нар ялангуяа иргэний байгууллагын, сошиал дээр үг хэлээ чөлөөтэй илэрхийлдэг тэр хүмүүсийн шаардлагын үр дүнд энийгээ больсон юм. Тэгээд ерөөсөө Эрүүгийн хуулиас “гүтгэх” гэдэг заалтыг авч байсан юм. Энэ бол маш дэвшилтэт зүйл. Тэгээд үүний дараа 2020 онд яасан бэ гэхээр манай Нямдорж гуай бол энэ заалтыг заавал оруулахын төлөө зүтгээд байсан л даа. Тэгээд яаж заалтаа оруулсан бэ гэхээр Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд бусдын нэр хүндэд халдах гэж заалт оруулаад тэрийгээ Зөрчлийн хуулиар энэ 31.1-ийг

зөрчих юм бол торгоно гэсэн ийм заалт оруулчихсан юм. Тэгээд үүний дагуу яаж байгаа вэ гэхээр өнөөдрийн байдлаар жишээ нь 1000 гаруй хүнийг жишээ нь прокурорын зөвшөөрөлгүйгээр, шүүхийн шийдвэргүйгээр хуулийн байгууллагууд аваачаад торгодог. Яах вэ, цагдаа голцуу байгаа, Тагнуулаас цөөхөн байгаа. Тэгээд тэд нар яадаг вэ гэхээр эхлээд 50 мянган төгрөгөөр торгодог, дараа нь 500 мянгаар торгодог, дараа нь 1 сарын баривчлах ял гээд тэгэнгүүт давтан үйлдсэн гээд баривчлах ял өгөнгүүт нөгөө хүмүүс бүгдээрээ чимээгүй болдог. Ийм зүйлүүд байгаад байгаа. Тийм учраас энэ хуулийг хэлэлцэхийг би түрүүчийн 11 сарын цаглавар дээр оруулахыг хүссэн. Тэгээд энэ дээр бас яг нөгөө хүний эрхийг бас тодорхой яг үг хэлэх эрх чөлөө, хэвлэн нийтлэх эрх чөлөөний төлөө манай Байнгын хорооны дарга маш тийм тэмцдэг. Дээрээс нь түрүүчийн Байнгын хорооны дарга Энхбаяр яг энэ хууль бол үнэхээр асуудалтай хууль юм байна лээ шүү гэж тэр Байнгын хороо дээр хэлж байсан. Тийм учраас энэ хуулийг та бүхэн хэлэлцээд ямар ч байсан хэлэлцэх асуудлын дараалалд оруулж өгөөч. Тэгээд дэмжих эсэхэд бол таны асуудал шүү дээ. Тийм байна. Тийм биз дээ? Тэгэхээр энэ дээр та саналаа хэлээд, тэгээд Байнгын хорооны гишүүдээр санал хураалгаж өгнө үү гэсэн ийм хүсэлт байна. Баярлалаа.

**Д.Цогтбаатар:** Өнөөдөр бол санал хураалт гэж байхгүй шүү дээ. Тэгэхээр ерөнхий таны ярьж байгаа асуудлын зарчимтай бол би санал нэг байгаа. Ялангуяа хэвлэн нийтлэх эрх чөлөө, сэтгүүлчдийн эрх чөлөөнд ил далдаар халдах ямар нэгэн ийм сэжүүр үүсгэж байгаад халдах гээд байгаа ийм эрсдэлт нөхцөлүүд байгаа бол энийг бид нар засах ёстой. Тэгээд энэ халдана гэдэг чинь ер нь ил халдах тухай ерөөсөө асуудал байдаггүй. Яадаг вэ гэхээр дандаа л нэг ийм далд сэмхэн хулгайн аргаар л халдах гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр хуульд ерөөсөө Үндсэн хуулийн тэр хэвлэн нийтлэх эрх чөлөө гэдэг бол

өөрөө халдашгүй маш ойлгомжтойгоор заачихсан байж байгаа юм байхгүй юу. Тэгэхээр энэ дээр бол ямар нэгэн тийм нууц, булхай арга бол хэрэггүй л дээ. Тийм учраас таны энэ асуудал намайг ажлаас авснаас хойш та анх удаа сөхөөд тавьж байна. Би энийг эргэж хараад яагаад одоо болтол энэ ороогүй байгаа юм. Тэгээд би тэгэхээр энэ асуудлыг цааш нь тавиад энд нь оруулах тал дээр нь ярья. Тэгээд ер нь зүгээр ярих нь зөв. Яг үнэн. Тэгээд яриад тал талаасаа энэ асуудлаа хэлэлцээд хаана, юу нь бас болохгүй байгаа юм. Энэ юмнуудыг нь ил тод ярьж байсан нь л зөв. Тэгэхээр би бол энэ асуудлыг хэлэлцүүлэх тал дээр нь холбогдох түвшиндээ яриадахъя.

Ингээд энэ асуудалтай холбогдож үг хэлэх гишүүд байна уу. Ингээд үг хэлэх гишүүд алга байна. Ингээд “Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 54,5 хувиар санал дэмжигдлээ.

11.27 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

**“Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолын төслийг хэлэлцье.**

Тогтоолын төслийг та бүхэнд бас тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Сүнжид, Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүүдэн шүүхтэй холбоотой асуудал эрхэлсэн гишүүн Цэлмэн ирсэн байж байна. Ингээд тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү.

Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

**Ц.Сандаг-Очир:** Энэ тогтоолтой холбогдуулаад Хүний эрхийн Үндэсний Комиссоос Байнгын хорооны даргын нэр дээр нэг ийм албан тоот ирснийг та бүхэн харсан байх. Тэгээд энэ дээр бол Цэлмэн Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс ер нь цаашидаа энэ Хүний эрхийн Үндэсний Комиссын бүтцэд бас Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн энэ чиглэлээр нэгжтэй болъё. Нэгжтэй болсноор дагаад бүтэц орон тоо, төсөв мөнгө, тамга тэмдэг, хэвлэмэл хуудастай болъё гэдэг ийм асуудлуудыг тавьсныг Хүний эрхийн Үндэсний Комисс нь бас өөрөө боломжгүй юм гэдэг ийм асуудлыг тавьсан байх юм. Тэгээд энэ ямар учиртай юм бэ. Хүний эрхийн Үндэсний Комисс өөрөө бас бие даасан хараат бусаар үйл ажиллагаа явуулах үндсэн чиг үүрэгтэй. Тэгээд бас Комиссын дотор ахиад нэгж бүтэц байгуулаад, ингээд явах нь ямар логиктой байна вэ. Тэгээд комиссын дарга болоод комиссын гишүүн 2-ын байр суурь бас өөр харагдаад байх юм. Энэ дээр бас Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга болоод Цэлмэн гишүүн бас өөр өөрсдийн байр сууриа илэрхийлээч. Ямар учир утгатай юм. Цогтбаатар гишүүний нэр дээр ирүүлсэн энэ албан тоот чинь ямар утга учиртай юм гэдгийг тодруулж өгөөч.

**Д.Цогтбаатар:** Ажлын хэсгийн микрофоныг өгье. Эхлээд 4 дүгээр микрофон.

**Д.Сүнжид:** Та бүхэнд өглөөний мэндийг хүргэе. Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Цэлмэн гишүүн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлыг дагнан хариуцдаг. Тэгээд хуулиараа 3 чиг үүрэг хэрэгжүүлэх учиртай. Өөрөө санал гаргах эрхтэй. Тэрнийхээ дагуу гаргасан саналын хүрээнд энэ бие даах эсэх асуудлыг шийдэж өгөөч гэдгийг уламжилсан. Комиссын гишүүд

хуралдаад энэ талаар хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулж байж бид нар шийдвэрлэх боломжтой. Өөрөөр хэлбэл Төсвийн тухай хуулиараа ерөнхийлөн захирагч, шууд захирагчийн асуудал нь нэгэнт тодорхойлогдож байгаа учраас бид нар Байнгын хорооны тогтоолоор юм уу, эсвэл комисс өөрөө дангаараа энэ төсвийн асуудал, тамга тэмдэг тусдаа хэрэглэх эсэх асуудал, хүний нөөцийг томилох эсэх асуудлыг бие даан шийдвэрлэх боломж нь Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль гэдгээрээ боломжгүй байгаа учраас хэрэгжилтийн үр дагавар нь үнэлгээ хийгээд комиссын тухай тэгээд энэ шинээр үүсгэн байгуулагдсан 3 механизмыг яаж уялдуулан хооронд нь үр дүнтэйгээр ажиллуулах вэ гэдгийг бид нар энэ хуулийн хэрэгжилтийн үр дагавар үнэлгээ хийж байж, тэгээд дараагаар нь хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах замаар энэ асуудлыг шийдвэрлэвэл зохистой юм гэдэг ийм байр суурийг илэрхийлж байгаа юм.

**Д.Цогтбаатар:** 5 номерын микрофон өгье.

**Я.Цэлмэн:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Монгол Улс эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг байгуулахдаа Эрүү шүүлтийн эсрэг конвенцод 2014 оны 12 сарын 11-ний өдөр нэгдэж орсон. Энэ нэмэлт протоколын үзэл баримтлалд нийцүүлж, Хүний эрхийн Комиссын тухай хуульд өөрчлөлт оруулсан байгаа 2020 онд. Энэ Хүний эрхийн Комиссын тухай хуулийн өөрчлөлтөөр бол эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа гэдэг нь өөрөө Хүний эрхийн Комиссоосоо хараат бус байх байдлаар хуульчилсан. Мөн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагаанд Комиссын гишүүн болон бусад албан хаагч бол хөндлөнгөөс нөлөөлөх оролцохыг хориглоно. Энэ өөрөө эрүүдэн шүүхээс

урьдчилан сэргийлэх үндэсний хэмжээний бие даасан цогц үйл ажиллагаа юм гэж хуульчилсан байдаг. Мөн Хүний эрхийн Комиссын тухай хууль дээр 2 төсөв байгаагийн 1 нь бол Хүний эрхийн Үндэсний Комиссын төсөв, нөгөөдөх нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний төсөв гээд ингээд заасан.

Мөн Хүний эрхийн комиссын тухай хуульд албан тушаалтнуудыг томилж байгаа 2 эрх олгосон албан тушаалтны талаар зохицуулалт байгаа. 1 нь Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Тамгын газраа даргыг томилж байгаа. Нөгөөдөх нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн өөрийн дор нь нэгж ажилладаг гэж хуульчилсан. Нэгж ажиллахаар. Тэр нэгжийнхээ даргыг бас мөн яах вэ томилж, дотоод зохион байгуулалтынхаа асуудлыг шийднэ гээд ингээд хуульчилсан байгаа.

Хүний эрхийн Комиссын тухай хуульд бол Хүний эрхийн комиссыг бол Хүний эрхийн Комиссын дарга бол гадаад, дотоодод бол төлөөлнө. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн гадаад дотоодод төлөөлж, хууль тогтоомж шийдвэрийн төсөл, түүнд санал өгөх ийм эрхтэй гэдгээр II эрхтэйгээр ингэж тулгуурлаж хуулийн зохицуулалт хийсэн. Үүний дагуу бол хуулийн хэрэгжилтийг хангаж өгөөч гэсэн хүсэлтийг бол Хууль зүйн байнгын хороонд хуульд заасан эрхийнхээ дагуу бол санал дэвшүүлсэн байгаа юм. Баярлалаа.

**Д.Цогтбаатар:** Тодруулах уу. Сандаг-очир гишүүний микрофоныг.

**Ц.Сандаг-Очир:** Тэгэхээр бас Сүнжид дарга аа, танайд чинь Хүний эрхийг хамгаалагчийг хамгаалах, Хүний хувийн мэдээллийг хамгаалах эд нар гээд ингээд механизмууд бий. Тэгэхээр цаашидаа ахиад Эрүү шүүлтээс урьдчилан

сэргийлэх энэ механизм чинь тусдаа бүтэцтэй болно гэвэл ахиад саяын энэ механизмууд ахиад тусдаа ийм бүтэцтэй болох ийм асуудлууд гарч ирж байна. Энийг юу гэж үзэж байгаа юм. Ингээд Хүний эрхийн Үндэсний Комисс чинь дотроо ингээд одоо байгаа бүтэц чинь бол наад Цэлмэн даргын чинь доор арга зүйн зөвлөгөө өгөх бүтэц, ажлын нэгж арга зүйн зөвлөгөө өгөх ийм нэгж орон тоо байж болохоор байгаа шүү дээ. Тэгээд ингэж ажиллаж болохгүй байгаа юм уу. Заавал ингэж тусдаа гарч, бүтэц орон тоотой байснаар үйл ажиллагаагаа явуулах бололцоо боломж нь бүрдээд байгаа юм уу. Энийг бас Цэлмэг дарга нэг хэлж өгөөч. Баахан дагасан ийм том хүүдий нээж өгөх нь байна шүү дээ.

**Д.Цогтбаатар:** Ажлын хэсэг 4 дүгээр микрофон өгье.

**Д.Сүнжид:** Сандаг-Очир гишүүний тодруулгад хариулъя. Тэгээд энэ бол яг тийм асуудал гарч байна. Хэрвээ бид нар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизмыг тусад нь яг бие даасан байгууллага байгуулна гэвэл I дүгээрт хуулиар шийдэх ёстой нэг асуудал байгаа юм.

2 дугаарт нөгөө 2 нэгж бол манай дотоод бүтэц болоод үйл ажиллагаагаа яг л хуульдаа нийцүүлээд л яваа. Тэгээд цаашидаа бас бусад энэ бие даасан яг тодорхой хүний эрхийн зорилтот бүлгийн ч юм уу асуудлыг хариуцсан байдлаар эсвэл одоо байгаа 2 нэгж маань бие даана гэвэл бас яах вэ гэдэг ийм асуудлуудыг бид нар тооцох л ёстой, учиртай байгаа юм. Ер нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц өөрөө ямар үүрэг хүлээлгэж байгаа вэ гэхээр улс орон үүний эсрэг арга хэмжээ авах ёстой. Үр дүнтэй байх ёстой гэж байгаа болохоос заавал ингээд төрийн байгууллага ч ер нь бол бие даах ёстой гэдэг ийм утга агуулга бол байхгүй юм байна лээ л дээ. Тэгэхээр бид нар энийг нөгөө хууль тогтоомжийн хүрээндээ бас шийдэх нь

зөв байх гэдэг ийм саналыг өгч байгаа юм.

Тэгээд 1 зүйл нээрээ тодруулаад хэлэхэд эрүү шүүлт.../минут дуусав/

**Д.Цогтбаатар:** 4 дүгээр микрофонд гүйцээгээд хариулчих. Тэгээд дараа нь Адьшаа гишүүн, тэгээд Адьшаа гишүүний дараа 5 дугаар микрофон бас хариултаа өгнө.

**Д.Сүнжид:** Эрүүдэн шүүгдлээ, хүнлэг бус хэрцгий хандлаа гэдэг гомдлыг бол комиссын гишүүд шийдэж байгаа. Манайх бид нар. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажиллагаа хийх хяналт шинжилгээ хийх ажлыг бол Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх гишүүн маань хариуцаж байгаа юм. Тэгэхээр энийгээ бас хооронд нь үр дүнтэй уялдуулахын тулд заавал тусдаа байх хэрэгтэй байна уу, үгүй юу гэдгийг бас бодолцож хууль тогтоомжуудаа нэмэлт өөрчлөлт оруулах, одоо байгаа хуулийн хэрэгжилтийг үр дагаврыг үнэлэх ёстой гэдэг ийм байр суурьтай байгаа юм.

**Д.Цогтбаатар:** Адьшаа гишүүний микрофон.

**Ш.Адьшаа:** Өнөөдөр хүний эрхийн асуудлаар Улсын Их Хурал олон нөхцөл байдал дээр дүгнэлт хийж хүний эрх зөрчигдөж байгаа, хүний эрхийн асуудал, хүний эрхийг хариуцсан байгууллагын бүтэц тогтолцоо, чиг үүргийн тухай 2020 онд Хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулсан. Энэ Хүний эрхийн Комиссын Эрүүдэн шүүх асуудал хариуцсан комиссоор дарга 2-ын энэ асуудал чинь ямар учиртай юм бэ. 2 Толгойтой могой болох гэдэг нэг үг байдаг. Та нар энэ хүний эрх хамгаалах асуудлаа л сайжруул. Тэрнээс биш гадаадад би том толгой төлөөлнө гэдэг ийм ганцхан зорилго агуулсан ийм юм байж болохгүй. Бид нар ажлаа сайжруулъя. Бүх эрх мэдэл чинь байгаа шүү дээ. Өнөөдөр дахиж бүтэц орон

тоо, дахиад нэг даргын, дахиад нэг байгууллагын төсөв хөрөнгийг энэ татвар төлөгчдийн мөнгөнөөс оруулж ир гэдэг ийм асуудлыг өнөөдөр Улсын Их Хурал дээр тавьж байгаадаа бас дүгнэлт хийгээрэй. Энэ яав ч байж болохгүй асуудал. Ажлаа сайжруул. Хүний эрх зөрчигдөж байгаа, Хүний эрхийг Үндсэн хуулийн түгээмэл зарчим, Олон улсын Хүний эрхийн түгээмэл зарчмын хүрээнд хүний эрх, эрх баригчид, хууль хүчний байгууллага, түүнчлэн иргэдийн эрх зорчих асуудал хэрээс хэтэрсэн. Энэ дээр та нар сайн ажилла. Тэрнээс биш дарга болоод, машин унаад, дээр нь тушаал гаргадаг ийм жижигхэн юмаар битгий төсөөл. Энэ чинь арай л та нарын энэ юм чинь сайн дүгнэлт хийгээрэй. Хүний эрхийн та нар хамгаалагчид. Монгол Улсын Их Хурал та нарын бүтэц орон тоо, цалин хөлс дээр бид онцгой анхаарч ирсэн шүү дээ. Ийм нэг увайгүй ч гэх юм уу, эрх мэдэлд би их шүүмжлэлтэй хандаж байна. Энэ яав ч байж болох асуудал биш. Тэгээд тэр дээр дотроо яриад зохицоод ажлаа сайжруулах тухай ярья.

**Д.Цогтбаатар:** Ажлын хэсгийн 5 дугаар микрофоныг өгчихье.

**Я.Цэлмэн:** Баярлалаа. Энэ нэгдээж орсон конвенц нь үзэл баримтлал нь угаасаа ийм 2 өөр конвенц байдаг. Яг энэ үзэл баримтлалд бол нэгдээж орсон Эрүү шүүлтийн эсрэг конвенц, түүний нэмэлт протоколд заасныхаа дагуу бол энэ Комиссын тухай хуулийг өөрчилж ингэж оруулсан. Одоогийн хуулийн зохицуулалт бол угаасаа бие биедээ хараат бусаар байх ёстой. Бие биеийнхээ ажилдаа орохгүй гээд ингээд цаанаас нь хуульчилчихсан байгаа юм. Тэгээд төсвийн тухай асуудал дээр бол мэдээж Адьшаа гишүүнд бас зарим зүйлийг тодруулж хэлэх нь зөв байх. Яагаад ингээд хуулийн хэрэгжилт дээр бид нар үр дагавар дээр шинжилгээ хийж өгөөч гэж байгаа юм бэ гэхээр бид бол Засгийн газар бол Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг



байгуулсан талаараа бол тайлангаа хүргүүлчихсэн. Энэ дээр бол мэдээж орон тооны асуудал байгаа. Орон тоог бол жил жилээр нэмүүлэх асуудал байдаг боловч ингээд 3 дахь жилдээ явж байгаа 5 хүний орон тоотойгоор. Ер нь бол өнөөдөр Монгол Улсын Төрийн албаны тухай хуулиар хэрэгжиж байгаа зүйлээр бол яг энэ комиссын тухай хууль маань өөрөө 2 ийм бие даасан механизмыг 2 бие даасан байдлаар нь хуульчилчихсан байгаа энэ хуулийн хэрэгжилтийг цаашид зөв хангуулах нь чухал юм гэсэн энэ саналыг л хүргүүлсэн байгаа.

**Д.Цогтбаатар:** Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асууж хариулт авч дууслаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү. Энх-Амгалан гишүүнээр тасаллаа. Энх-Амгалан гишүүний микрофоныг өгье.

**Б.Энх-Амгалан:** Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс энэ хүний эрх, эрх чөлөө, зөрчигдөж болзошгүй аливаа шалтгаан нөхцөлийг урьдчилан судлах, тогтоох, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хийдэл зөрчлийг арилгах ийм л үндсэн үүрэгтэй байгууллага шүү дээ. Тэгээд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль дотор чинь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизм, Хүний эрхийг хамгаалагчийг хамгаалах тухай, Хүний хувийн мэдээллийг хамгаалах механизм чинь бүгд багтаад энийг чинь Хүний эрхийн Үндэсний Комисс өөрөө хариуцаж байгаа биз дээ. Тэгэхээр энийгээ аваачаад нэгдэн орсон конвенц нь ийм юм. Хуулийн зохицуулалт ийм юм, тусдаа гаръя, төсөв санхүү хэрэгтэй, Комиссын дэргэд комисс байгуулъя гэдэг чинь яаж болох юм бэ. Энэ чинь болохгүй шүү дээ. Тэгээд энэ чинь 1 дүгээрт хүний эрхийнхээ хамгаалах тогтолцооны нэгдмэл байдлыг алдагдуулна. Төсөв, санхүү чинь хүндрэл

учирна. Хүний нөөц чинь тогтвортой байлгах асуудал нь эргээд бодлого болж хувирна. Нэгдсэн байдал чинь алдагдана.

Тийм учраас энийг дэмжиж бол чадахгүй юм байна. Харин зүгээр тэр хуульд тэгээд заачихсан бол буцаагаад хуулийг нь Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль дотор нь оруулаад л нэгтгээд л, тэгээд л Хүний эрхийн Үндэсний Комисс энийгээ аваад л явдаг юм байгаа биз. Түүнээс одоо энэ чинь явж байгаад энэ 3 чиглэл чинь гурвуулаа салах нь байна шүү дээ. Тэгээд Хүний эрхийн Үндэсний комисс чинь өөрөө юу хийх юм. Бие даасан 3 салбар комисстой болох юм уу. Ийм байдлаар бол цаашаа явж болохгүй байх.

Тэгээд бас нэг юмыг та нар маань анхаараарай. Хүний эрх, хүний эрх гээд бид нар юм яриад л байна. Яг нарийндаа яривал энэ Олон улсын гэрээ, конвенц дотоодын хууль, тогтоомжид нийцүүлбэ барья гээд л нэгдчихсэн учраас бид нар ингэе гэхээсээ илүүтэйгээр Монгол хүний эрх хамгийн 1 дүгээрт шүү. Монгол хүний эрхийг хамгийн түрүүнд Хүний эрхийн Үндэсний Комисс хамгаалах ёстой шүү гэдэг. Түүнээс тэр гадна дотных нь юмыг нь яах вэ. Тэр нь тэгээд олон улсынхаа хууль дүрмээр явдаг л юм байгаа биз. Монгол газар шороон дээр Монгол хүний эрх хамгийн түрүүнд шүү.

Тийм учраас монголчуудынхаа эрх ашгийг хамгаалах нь чухал шүү гэдэг ийм асуудлуудыг бид нар ярих ёстой юм шүү. Тийм учраас энийг бол дэмжиж боломжгүй юм байна шүү. Энэ дээр Хүний эрхийн Үндэсний Комисс дахиж хуралдаж юмнуудаа хараарай даа. Тийм юмнуудыг хэлье.

**Д.Цогтбаатар:** Ингээд энэтэй холбогдуулаад би бас нэг зүйлийг хэлчихмээр байгаа юм. Энэ орж ирж байгаа тогтоолын маань төсөл яг ийм асуудал байгаа учраас Байнгын хороог энэ дээр үнэлгээ дүгнэлт өг. Яагаад гэвэл 2 өөр асуудал өөрийн эрхгүй гараад ирж

байна шүү дээ. Тэгээд 2 талаас ингээд тавьчихсан байгаа учраас хүний эрхийн дэд хороонд ч, Хууль зүйн байнгын хороонд ч энэ асуудал дээр юу болоод байгаа юм бэ, яаж байгаа юм бэ, Хууль зүйн байнгын хороо энийгээ аваад судлаад үз гэж байгаа юм. Тогтоолын маань төсөл энэ. Нөхцөл байдал яг амьдрал дээрээ юу байгаа гэхээр Эрүүдэн шүүх конвенц чинь бол ийм шүү дээ. Бид нар нэгдэн орчихсон байхгүй юу. Соёрхон баталчихсан. Энэ чинь Монголын хууль. Өөрөөр хэлбэл бид нар Хүний эрхийн Комиссоо батлахдаа энэ конвенцдоо заасан юмыг нь нарийсгаад Хүний эрхийн Комисс руугаа аваачаад хийчихсэн байхгүй юу. Асуудал нь Их Хуралдаа бас байгаа. Тэгээд эндээ оруулчихаад одоо энэ асуудал нь өөрийн эрхгүй гарч ирчхээд байхгүй юу.

Яагаад гэвэл конвенц нь тусдаа байна гээд заачихсан. Тэрэнд нь бид орчихсон. Өнөөдөр Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль бөгөөд Хүний эрхийн Комиссын хуультайгаа аваад үзэх юм бол Олон улсын хууль нь давамгайлна шүү дээ. Яг үүгээрээ бид нар нөгөө нэгдэн орчихсон, соёрхон баталчихсан конвенц бол.

Тэгэхээр өнөөдөр манай өөрийн үйлчилж байгаа хууль нь тусдаа байлгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг нь бид нар нэг тал руу нь нээрээ гаргаж өгөхгүй бол яг өөрсдийн чинь юм ярьж байгаа бүгдийн асуудал зөв. Яагаад гэхээр ийм ойлгомжгүй байдалтайгаар энэ эд нарын ойлгомжгүй байдал хүний эрхийн нөхцөл байдалд нөлөөлнө шүү дээ. Энэ чинь эзэнгүйдэх гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг нь бол судалж үзэх хэрэгтэй болно гэсэн үг.

Ингээд үг хэлж, асуулт асууж, хариулт авч дууслаа.

“Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75

жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Сандаг-Очир гишүүнээр асуудлыг Улсын Их Хурлын нэгдсэн чуулган дээр танилцуулъя.

Ингээд байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье ээ. Гишүүдэд ирсэнд.

11.45 цаг.

**Дууны бичлэгээс буулгасан:**  
**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

**Э.СУВД-ЭРДЭНЭ**